



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 26 (551)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Дайнд оролцсон ахмад настнуудын талаар авах зарим арга хэмжээний тухай*
- *Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 70 жилийн ойг тэмдэглэх тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Төсвийн зардлыг хэмнэх зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2008 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2008 оны долдугаар сарын 10

№26 (551)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

377.	Прагиба Мета-г "Алтан гадас" одонгоор шагнах тухай	Дугаар 122	750
378.	Окада Хидэкирог "Алтан гадас" одонгоор шагнах тухай	Дугаар 123	751
379.	Мун Ги Буг-ийг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 124	751
380.	Жон Пирийг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 125	751
381.	Зарим офицер, ахлагч нарыг "Энхийн төлөө" медалиар шагнах тухай	Дугаар 148	751
382.	Элчин сайдыг эгүүлэн татах тухай	Дугаар 149	752
383.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 150	752
384.	Балжиннямын Жамъяндагвад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай	Дугаар 151	755
385.	Цэдэвдоржийн Базаррагчаад Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 152	756
386.	Бизъяагийн Дашзэвэгт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 153	756
387.	Нацагийн Мэндбаярт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 154	756
388.	Банзрагчийн Тунгалагт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 155	756
389.	Батсуурийн Цэрэннадмидад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 156	757
390.	Түдэвдоржийн Эрхэмбаатарт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 157	757
391.	Самдангийн Отгонгэрэлд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 158	757
392.	Очирын Цэвэгдоржид Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 159	757
393.	Мижиддоржийн Тогтохнямд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 160	758
394.	Төмөрбаатарын Доржжүгдэрт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 161	758
395.	Лхагвын Ганпүрэвт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 162	758
396.	Айда Григорьевна Пыньког "Алтан гадас" одонгоор шагнах тухай	Дугаар 163	758
397.	Чойжилжавын Цэвээнпүрэвт Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай	Дугаар 166	759
398.	Жак Доутыг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 167	759
399.	Дайнд оролцсон ахмад настнуудын талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 170	759
400.	Элчин сайдыг томилох тухай	Дугаар 171	759
401.	Дэлхийн сонгодог утга зохиолын 50 боть хэвлүүлэх тухай	Дугаар 172	760

402.	"Монгол Улсын Үндэсний Номын сан" байгуулах тухай	Дугаар 173	760
403.	Цолны ялгах тэмдгийн тодорхойлолт, загвар батлах тухай	Дугаар 174	761
404.	Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай	Дугаар 175	765
405.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 189	765
406.	Элчин сайдыг эгүүлэн татах тухай	Дугаар 190	766
407.	Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 70 жилийн ойг тэмдэглэх тухай	Дугаар 191	766
408.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 192	767
409.	Элчин сайдыг томилох, чөлөөлөх тухай	Дугаар 193	767
410.	Зарим хүмүүсийг Ерөнхий шүүгч, шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 197	767
411.	Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай	Дугаар 198	768

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

412.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 92	768
413.	Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай	Дугаар 125	769
414.	Төсвийн зардлыг хэмнэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 128	770
415.	Монголын Үндэсний түүхийн музейг өөрчлөх тухай	Дугаар 129	771
416.	Төсөл хэрэгжүүлэх тухай	Дугаар 136	771
417.	Тусгай зориулалтаар 2009 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай	Дугаар 140	773
418.	Хөтөлбөр хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 144	774
419.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 149	775
420.	"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 153	775
421.	Гамшиг судлалын хүрээлэн байгуулах тухай	Дугаар 156	775
422.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 157	776
423.	Техникийн зохицуулалтын тухай	Дугаар 159	776
424.	Тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай	Дугаар 161	780

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 122

Улаанбаатар хот

Пратиба Мета-г "Алтан гадас" одонгоор шагнах тухай

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон НҮБ-ын төрөлжсөн бусад байгууллагаас манай улсад үзүүлж буй дэмжлэг тусалцааг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд чиглүүлэн идэвх санаачилга гарган ажиллаж, Монгол Улсыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж

НҮБ-ын Суурин зохицуулагч, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч хатагтай Пратиба Мета-г "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 123

Улаанбаатар хот

Окада Хидэхирог "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, Япон Улсын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, монгол судлал болон монголын эрт, дунд үеийн түүхийн судалгаанд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Токиогийн Гадаад судлалын их сургуулийн зөвлөх профессор,

монголч эрдэмтэн Окада Хидэхирог "Алтан гадас" одонгоор шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

Мүн Ги Буг-ийг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, БНСУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, манай улсын зөловсрол, биеийн тамир, спорт, соёл урлагийн салбарын хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж БНСУ-ын иргэн, "Монгол наадам" дээд

сургуулийн ерөнхий захирал Мүн Ги Буг-ийг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 125

Улаанбаатар хот

Жон Пирийг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, ИБУИНВУ-ын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, манай улсын хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ИБУИНВУ-ын иргэн, "Кембридж Монголын гамшгийн эсрэг уриалга" хандивын

байгууллагын гүйцэтгэх захирал Жон Пирийг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

Зарим офицер, ахлагч нарыг "Энхийн төлөө" медалиар шагнах тухай

Ардчилсан Конго улсад НҮБ-ын цэргийн хяналтаар болон Афганистаны Үндэсний Армийг хөгжүүлэх хөтөлбөр-ийн сургалтын хөдөлгөөнт багт

оролцон үүргээ нэр төртэй биелүүлсэн Зэвсэгт хүчний цэргийн багийн дор дурдсан офицер, ахлагч нарыг "Энхийн төлөө" медалиар шагнасугай.

"ЭНХИЙН ТӨЛӨӨ" МЕДАЛИАР :

1. Хартолгойн Банди - ЗХ-ний 120 дугаар ангийн захирагчийн 1 дүгээр орлогч, ерөнхий инженер, хошууч

3. Залуугийн Батмөнх - ЗХ-ний 123 дугаар ангийн артиллерийн зэвсэглэл хадгалах тасгийн нярав, ахлагч

2. Өлзийбаярын Батжаргал - ЗХ-ний 016 дугаар ангийн артиллерийн дарга, дэд хурандаа

4. Содномын Болдбаатар - ЗХ-ний 015 дугаар ангийн захирагчийн орлогч, ерөнхий инженер, дэд хурандаа



- | | |
|--|--|
| 5. Доржийн Ганбаатар - ЗХ-ний 327 дугаар ангийн зэвсгийн даргын туслагч, ахлах дэслэгч | дугаар ангийн артиллерийн салааны тасгийн захирагч-тануулчин, ахлах дэслэгч |
| 6. Гангүрөвийн Ганзориг - ЗХ-ний 120 дугаар ангийн салааны захирагч, ахлах дэслэгч | 12. Сандагдоржийн Тэмүүлэнзаяа - ЗХ-ний 256 дугаар ангийн артиллерийн тануулын дарга, ахлах дэслэгч |
| 7. Доржжүгдэрийн Ганхөлөг - БХИС-ийн Цэргийн дээд сургуулийн дадлагын багш, ахлах ахлагч | 13. Батнасангийн Энхболд - ЗХ-ний 120 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч |
| 8. Найдансүрэнгийн Саранбат - ЗХ-ний 065 дугаар ангийн 278 дугаар салбарын захирагчийн орлогч, ахлах дэслэгч | 14. Содномбалжирын Эрдэнэбаатар - ЗХЖШ-ын Ар талын газрын цэргийн зэвсэглэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, хурандаа |
| 9. Далхжавын Сэргэлэн - ЗХ-ний 119 дүгээр ангийн захирагчийн орлогч, ерөнхий инженер, хошууч | 15. Ишнанаагийн Эрдэнэбаяр - ЗХ-ний 065 дугаар ангийн 281 дүгээр салбарын аэродромын хадгалах тасгийн дарга, ахлах дэслэгч |
| 10. Энэбишийн Сэтэвдагва - ЗХ-ний 167 дугаар ангийн артиллерийн дарга, дэд хурандаа | 16. Ийчилийн Эрдэнэсүрэн - ЗХ-ний 015 дугаар ангийн төлөвлөлтийн офицер, ахмад |

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.ЭНХБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 149

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

сайд Чулууны Батжаргалыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Гэгээн Ширээт Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Данзанноровын Болдбаатарыг томилсугай.

1. Монгол Улсаас Гэгээн Ширээт Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.ЭНХБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 150

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, хэвлэл мэдээлэл, төр захиргааны

болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН
ТУГИЙН ОДОНГООР:**

1. Лхамсүрэнгийн Лхагвасүрэн - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 12 дугаар сургуулийн ахмад багш

2. Дэнсмаагийн Норовсамбуу - Хөвсгөл аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга
3. Жамъяны Цогбат - УДБЭТ-ын тайзны ерөнхий машинист



“АЛТАНГАДАС” ОДОНГООР:

1. Халзангийн Амаржаргал - Дархан-Уул аймгийн Анагаах ухааны коллежийн тэнхимийн эрхлэгч
2. Дашзэвэгийн Амарсайхан - АМГТХЭГ-ын хэлтсийн дарга
3. Лувсанцэрэнгийн Ариунжаргал - МҮОНРТ-ийн Хүүхэд, залуучуудын редакцийн найруулагч
4. Сундуйн Бадарч - ХААИС-ийн маркетингийн тэнхимийн эрхлэгч
5. Дэмид-Осорын Баярсайхан - Хэнтий аймгийн Холбооны ахлах техникч
6. Лхагважавын Баярсайхан - Завхан аймгийн “Чандмань-Эрдэнэ” цогцолбор сургуулийн захирал
7. Тамзавын Баярсайхан - УДБЭТ-ын найрал дуучин
8. Годгойн Баярхүү - Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сум дахь Сум дундын хүн эмнэлгийн ерөнхий эмч
9. Сандагдоржийн Бэгзсүрэн - Хөвсгөл аймгийн Нисэх буудлын дарга
10. Ядамсүрэнгийн Ган-Очир - Ховд аймгийн Мянгат сумын харьяат уяач
11. Галбадрахын Гантөмөр - Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн дарга
12. Төмөр-Ухнын Дандар - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 33 дугаар сургуулийн химийн багш
13. Гүрбазарын Дансран - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 12 дугаар сургуулийн монгол хэлний багш
14. Нямын Дашцэрэн - Булган аймгийн Хишиг-Өндөр сумын цэцэрлэгийн эрхлэгч
15. Санжаагийн Доржсүрэн - ШУТИС-ийн КТМС-ийн менежментийн салбарын багийн тэргүүлэх профессор
16. Бүрэнтэгшийн Жамбалдорж - Орхон аймгийн Баян-Өндөр сумын өндөр настан, ахмад уурхайчин
17. Төмөрхүүгийн Жүгдэрнамжил - Булган аймгийн Баян-Агт сумын Баянзүрх багийн эмч
18. Чулууны Мандшир - Завхан аймгийн Тэлмэн сумын дунд сургуулийн багш, эрхлэгч
19. Бүдээгийн Мөнхтуяа - Монгол Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын бэйнгын хорооны дарга
20. Эрдэнэжавын Мягмарпүрэв - Монголын хэвлэлийн үйлдвэрүүдийн холбооны тэргүүн
21. Дуламын Найдан - Булган аймгийн Гурванбулаг сумын малчин
22. Даваагийн Нансалжав - Увс аймгийн Хяргас сумын Засаг дарга
23. Санжаагийн Нарантуяа - Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
24. Дондогдоржийн Наранцацралт - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 65 дугаар сургуулийн захирал
25. Дугарнямын Оюун - ТЗҮААЭГ-ын харъяа Засгийн газрын 3 дугаар байрны нягтлан бодогч
26. Лхагва-Очирын Оюунчимэг - ТЗҮААЭГ-ын үйлчлэгч
27. ШагдарынӨлзийбаяр - Хөвсгөл аймгийн “Хөвсгөл геологи” ХХ-ийн механик
28. Чойжилын Пүрэвдорж - Ховд аймгийн Дарви сумын малчин
29. Гэжээгийн Пүрэвжав - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 2 дугаар хорооны өндөр настан, Ахмадын зөвлөлийн дарга
30. Аюушийн Рагчаа - Өмнөговь аймгийн Даланзадгад сумын “Эрдмийн гэгээ” сургуулийн захирал
31. Авирмэдийн Сүрэнжав - ТЗҮААЭГ-ын харъяа Автобаазын жолооч
32. Норовсүрэнгийн Тогтохбаяр - ХААИС-ийн Биологийн нөөцийн менежментийн сургуулийн захирал
33. Нас-Уртын Түгжсүрэн - ШУТИС-ийн ТТИС-ийн тэргүүлэх профессор
34. Лувсанрэнчингийн Тэгшжаргал - Завхан аймгийн Тэлмэн сумын дунд сургуулийн захирал
35. Мухаагийн Халидолда - Ховд аймгийн Ховд сумын харьяат уяач
36. Ундрахын Цогзолмаа - Завхан аймгийн Сонгино сумын Хүн эмнэлгийн их эмч
37. Чулуунбаатарын Цогтбаатар - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний “Цорс буянт” ХХК-ийн захирал
38. Ганбаатарын Цолмон - УДБЭТ-ын балетын бүжигчин
39. Оригийн Цэнд - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 12 дугаар сургуулийн түүх, газар зүйн багш
40. Цагаанхүүгийн Цэнджав - ШУТИС-ийн ЭХИС-ийн багш
41. Хайдавын Чилаажав - МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүн, дарга
42. Галдангийн Чимэд - Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын малчин
43. Содномцэрэнгийн Чулуунцэцэг - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн
44. Шаравын Шүрэнцэцэг - Төрийн тусгай албан хаагчдын Нэгдсэн эмнэлгийн мэс заслын сувилагч



45. Цэрэндоржийн Энх-Амар - Өвөрхангай аймгийн Нисэх буудлын нислэгийн удирдагч
46. Халтарын Энхжаргал - ШУТИС-ийн ЭХИС-ийн захирал

47. Содовын Энхсонин - Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн баталгаажуулалтын лабораторийн улсын шалгагч

ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНГООР:

1. Жамцын Алтангэрэл - Булган аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга
2. Доржсүрэнгийн Сосорбарам - Төрийн тусгай албан хаагчдын Нэгдсэн эмнэлгийн сэргээн засах кабинетын эрхлэгч, дэд хурандаа

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

- | | |
|---|--|
| 1. Янсангийн Амартүвшин - Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн гэмтлийн их эмч | 18. Дүгэржавын Дамдинсүрэн - ШУТИС-ийн ахлах багш |
| 2. Хуушингийн Бааюу - Говь-Алтай аймгийн Цээл сумын малчин | 19. Сүрэнгийн Далайтогтох - Увс аймгийн Баруунтуруун сумын багийн Засаг дарга |
| 3. Арилдий Бадамханд - Нийслэлийн Баянзүрх дүүргийн "Гэгээрэл хөгжлийн төв"-ийн багш | 20. Бишүүбазарын Дашзэвэг - Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн эх барих, эмэгтэйчүүдийн их эмч |
| 4. Санжаагийн Байгалтөгс - ШУТИС-ийн КТМС-ийн салбарын эрхлэгч | 21. Дашдоржийн Долгорсүрэн - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн химийн багш |
| 5. Очирын Балжинням - Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын машинист | 22. Сосорбурамын Долгорсүрэн - Завхан аймгийн Тэлман сумын 11 жилийн сургуулийн багш |
| 6. Дашдэлэгийн Батмөнх - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн "Орчлон" дунд сургуулийн ерөнхий захирал | 23. Раажимбагийн Дүүваа - Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын холбооны салбарын эрхлэгч |
| 7. Замбын Бат-Очир - "Монголросцветмет" ХХК-ийн геологи хайгуулын экспедицид жолооч | 24. Сономдашийн Жаргалсайхан - Дорноговь аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дээд ахмад |
| 8. Шармаадайгийн Батсайхан - Говьсүмбэр аймгийн "Шивээ-Овоо" ХХК-ийн жолооч | 25. Сангийн Лувсанвандан - Говьсүмбэр аймгийн НААҮ-ний "Ус-Ду" ОНӨҮГ-ын захирал |
| 9. Надмидын Батхүү - ИНЕГ-ын Техникийн хангалтын албаны цахилгааны техникч | 26. Дашзэвэгийн Лувсандорж - "Соёмбо принтинг" ХХК-ийн ерөнхий захирал |
| 10. Загдын Баянзул - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 84 дүгээр сургуулийн бага ангийн багш | 27. Хувцдаганы Лхагвамаа - Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар сургуулийн монгол хэл, уран зохиолын багш |
| 11. Пунцагийн Баярсайхан - ИНЕГ-ын Техникийн хангалтын албаны инженер | 28. Банзрагчийн Лхагвасүрэн - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн амбулаторийн эрхлэгч |
| 12. Гомбожавын Буяа - Булган аймгийн Гурванбулаг сумын малчин | 29. Пүрэвийн Найданзул - Нийслэлийн уул уурхайн "Багануур" ХК-ийн албаны дарга |
| 13. Жигжидийн Гажсүрэн - Нийслэлийн 115 дугаар цэцэрлэгийн эрхлэгч | 30. Дуламсүрэнгийн Наранбаатар - Нийслэлийн уул уурхайн "Багануур" ХК-ийн эксковаторын машинч |
| 14. Сумъяагийн Ганболд - ТВ-9 телевизийн эфирийн найруулагч | 31. Найдангийн Наранцэцэг - ШУА-ийн Физик, технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний туслах ажилтан |
| 15. Норолхойн Гансиймаа - Ховд аймгийн Алтай сумын хүн эмнэлгийн Алтангадас багийн бага эмч | 32. Аюурзанын Оюунтуяа - Өмнөговь аймгийн ХХААГ-ын менежер |
| 16. Лувсандоржийн Даваасүрэн - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Сэргээн засалтын үндэсний төвийн албаны дарга | |
| 17. Дугарын Дамдин - Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлгийн сэтгэц, наркологийн зөвлөх эмч | |

33. Далайн Оюунтуяа - ТEG-ын Төрийн холбооны газрын шууданч
34. Найдангийн Оюунчимэг - Өмнеговь аймгийн Холбооны газрын хяналтын байцаагч
35. Цэрэнбадамын Оюунчимэг - ШУТИС-ийн ахлах багш
36. Цэрэнгийн Сайнбуян - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн ахлах эмч
37. Пунцагийн Саранцэцэг - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Хүүхдийн клиник сувиллын ерөнхий эмч
38. Цэнджавын Тунгалаг - Хүүхэд асран хүмүүжүүлэх төвийн дэд захирал
39. Лувсангийн Түмэндэмбэрэл - Орхон аймгийн Баян-Өндөр сумын Хүрэнбулаг багийн Засаг дарга
40. Гомбодоржийн Уртнасан - Дархан-Уул аймгийн Хонгор сумын хүн эмнэлгийн сувиллагч
41. Пүрэвдоржийн Цэдэврэнцэн - Орхон аймгийн Эрдэнэт УБУ-ийн Мэдээллийн хэлтсийн операторч
42. Донтовын Цэдэнсодном - Өмнеговь аймгийн Холбооны газрын монтер-жолооч
43. Жамбаагийн Цэрэндолгор - "Чөлөөт хэвлэл сан" сонины хэвлэх үйлдвэрийн монтажчин
44. Алтангэрэлийн Цэрэндулам - Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн лабораторийн нян

судлагч, их эмч

45. Ванчингийн Цэрэннадмид - Дархан-Уул аймаг дахь "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн дэд захирал
46. Хинатын Цэрэнлхам - Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмэгтэйчүүдийн эмч, ерөнхий мэргэжилтэн
47. Цэцэгэнгийн Цэцэгмаа - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 6 дугаар сургуулийн бага ангийн багш
48. Чойжинжавын Цэцэгмаа - "Монгол даатгал" ХХК-ийн Налайх дүүрэг дэх тасгийн менежер
49. Хэнмэдэхийн Цэцэгсүрэн - ТЗУААЭГ-ын харьяа Амралт, үйлчилгээний цогцолборын үйлчлэгч
50. Цэвээний Энх-Амгалан - ШУА-ийн Физик, технологийн хүрээлэнгийн лабораторийн эрхлэгч
51. Бямбадаваагийн Энхсайхан - Нийслэлийн худалдаа үйлчилгээний "ТБД-Андууд" ХХК-ийн гүйцэтгэх захирал
52. Намсрайн Энхцэцэг - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 12 дугаар сургуулийн нийгмийн ажилтан
53. Гомбын Эрдэнэчулуун - "Эгшиглэнт тэнхлэг холбоо" ТББ-ын уран бүтээлийн нэгдлийн эрхлэгч

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Лувсандоржийн Болд - Орхон аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын офицер
2. Бадарчийн Нарантуяа - ТТАХ-ын Нэгдсэн эмнэлгийн хүлээн авах тасгийн эрхлэгч

3. Балсанжавын Хишигдэлгэр - ТТАХ-ын Нэгдсэн эмнэлгийн арьс-гоо заслын эмч

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот

Балжиннямын Жамъяндагвад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Соёл урлаг, боловсролын байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж дэлхийн сонгодог болон үндэсний олон арван балет, бүжгэн жүжгийг мэргэжлийн өндөр түвшинд найруулан тавьж үзэгчдийн хүртээл болгон, үндэсний балетын бүжигчдийг сургаж бэлтгэх, ур чадварыг нь дээшлүүлэх, Монгол Улсад балетын урлагийг үүсгэн хөгжүүлж олон улсын хэмжээнд уурталчлахад оруулсан онцгой хувь нэмрийг нь

үнэлж Улсын дуурь, бүжгийн эрдмийн театрын уран сайхны удирдагч Балжиннямын Жамъяндагвад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" гэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 152

Улаанбаатар
хот

Цэдэвдоржийн Базаррагчаад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Хэвлэл мэдээлэл, боловсрол, утга зохиолын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж уран зохиолын тууж, өгүүллэг, нийтлэлийн болон орчуулгын шилдэг бүтээлүүд туурвиж, хятад судлалын үндэсний боловсон хүчин, эрдэмтдийг сургаж бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж

МУИС-ийн багш, доктор, профессор Цэдэвдоржийн Базаррагчаад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 153

Улаанбаатар
хот

Бизъяагийн Дашзэвэгт Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Хэвлэл мэдээллийн байгууллагуудад олон жил үр бүтээлтэй ажиллаж утга зохиол, сэтгүүл зүйн олон төрлөөр шилдэг бүтээлүүд туурвиж, Монголын радио, телевиз болон сэтгүүл зүйн хөгжилд оруулсан хувь нэмрийг нь үнэлж олон улсын сэтгүүлч, улс

төрийн тоймч Бизъяагийн Дашзэвэгт Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 154

Улаанбаатар
хот

Нацагийн Мэндбаярт Монгол Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Соёл урлагийн байгууллагуудад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, нийтийн ба найрал дуу, симфони, үлээвэр найрал хөгжмийн марш болон бусад хөгжмийн урлагийн төрлөөр олон шилдэг бүтээл туурвиж, Монголын хөгжмийн урлагт оруулсан хувь нэмрийг нь үнэлж

хөгжмийн зохиолч Нацагийн Мэндбаярт Монгол Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 155

Улаанбаатар
хот

Банзрагчийн Тунгалагт Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж дэлхийн сонгодог болон үндэсний жүжиг, уран сайхны кино, теле-жүжгийн гол ба туслах дүрүүдийг чадварлаг бүтээж, монголын орчин үеийн театр, тайз дэлгэцийн урлагийн хөгжилд оруулсан хувь нэмрийг нь үнэлж

Монголын урлагийн ажилтны холбооны гүйцэтгэх захирал Банзрагчийн Тунгалагт Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 156

Улаанбаатар хот

Батсуурийн Цэрэннадмидад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Соёл урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, монгол үндэстний болон гадаад орны ардын бүжгийг мэргэжлийн өндөр ур чадвар гарган гоцлон бүжиглэж, чуулгын урын санг баяжуулах, үндэсний бүжгийн урлагийг өөрийн орон төдийгүй гадаад оронд сурталчлах, ардын урлагийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж

Үндэсний дуу, бүжгийн эрдмийн чуулгын ахмад жүжигчин Батсуурийн Цэрэннадмидад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ****Н.ЭНХБАЯР****МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2008 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

Түдэвдоржийн Эрхэмбаатарт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэнд, боловсролын салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллан анагаах ухааны чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээний бүтээлүүд туурвиж, эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарыг бэлтгэх, эмнэлгийн практикт эмчилгээ-оношлогооны шинэ аргуудыг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг боловсронгуй болгох, эх нялхсын эрүүл мэндийг хамгаалахад оруулж

байгаа хувь нэмрийг нь үнэлж Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн ерөнхий захирал, доктор, профессор Түдэвдоржийн Эрхэмбаатарт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ****Н.ЭНХБАЯР****МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2008 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

Самдангийн Отгонгэрэлд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт үр бүтээлтэй ажиллаж эмнэлгийн материаллаг баазыг бэхжүүлэн гэмтэл согогийн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг сайжруулж, яс үеийн гэмтлийн оношлогоо, эмчилгээнд анагаах ухааны эрчин үеийн арга, техник, технологийг амжилттай нэвтрүүлэн хүн амын эрүүл мэндийг хамгаалахад

оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Гэмтэл согог судлалын төвийн ерөнхий захирал Самдангийн Отгонгэрэлд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ****Н.ЭНХБАЯР****МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2008 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

Очирын Цэвэгдоржид Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллан сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүд туурвиж, боловсролын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалтыг боловсронгуй болгон материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин, ажилчдыг бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг нь

үнэлж Улаанбаатар их сургуулийн тэнхмийн эрхлэгч, доктор, профессор Очирын Цэвэгдоржид Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ****Н.ЭНХБАЯР**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 160

Улаанбаатар хот

Мижиддоржийн Тогтохнямд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Хүүхэд, залуучуудын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж хүүхдийн байгууллагын хөгжлийн чиг хандлага, хүүхдийн хөгжил хамгааллын бодлогыг тодорхойлох, тус байгууллагын тогтолцоог бүрдүүлэх, хүүхэд, өсвөр үеийг сурган хүмүүжүүлж, хөгжүүлэх, тэдний эрх ашгийг хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг

нь үнэлж Хүүхдийн төлөө үндэсний газрын дарга Мижиддоржийн Тогтохнямд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот

Төмөрбаатарын Доржжүгдэрт Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж орон нутгийн боловсролын байгууллагуудыг чадварлаг удирдан сургууль, багш нарыг хөгжүүлэх чиглэлээр олон бүтээлч санаачилга гарган бодит ажил болгож, сургалтын агуулга, арга технологийг өөрчлөн шинэчлэх, багш нарын заах арга, үр чадварыг дээшлүүлэхэд оруулж

байгаа хувь нэмрийг нь үнэлж Хөвсгөл аймгийн Боловсрол, соёлын газрын арга зүйч Төмөрбаатарын Доржжүгдэрт Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

Лхагвын Ганпүрэвт Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай

Барилга, хүнс, хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээний салбарт санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, барилгын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, орчин үеийн техник технологиор бүрэн хангагдсан мах боловсруулах үйлдвэр байгуулан хүн амыг хүнсний бүтээгдэхүүнээр хангах, ажлын байр бий болгоход оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

үйлдвэр, худалдааны "Тайж трейд" ХХК-ийн ерөнхий захирал Лхагвын Ганпүрэвт Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 163

Улаанбаатар хот

Айда Григорьевна Пыньког "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, Оросын Холбооны Улсын боловсролын салбарын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын иргэн, Монгол-Оросын хамтарсан "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн 19 дүгээр сургуулийн

багш Айда Григорьевна Пыньког "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 06 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар 166

Улаанбаатар хот

Чойжилжавын Цэвээнпүрэвт Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээх тухай

Мэргэжлийн боксын спортын төрлөөр тив, дэлхийн болон бүсийн чанартай тэмцээнүүдэд амжилттай оролцон эх орныхоо нэр алдрыг дурсгаж, боксын спортын хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж мэргэжлийн боксын тамирчин

Чойжилжавын Цэвээнпүрэвт Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 06 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар 167

Улаанбаатар хот

Жак Дуутыг "Найрамдал" медалиар шагнах тухай

Мэргэжлийн боксын спортын төрлөөр олон шилдэг тамирчин бэлтгэж, монголын биеийн тамир, спортын салбарын хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ИБУИНВУ-ын иргэн, мэргэжлийн

боксын дасгалжуулагч Жак Дуутыг "Найрамдал" медалиар шагнасуугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 06 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар 170

Улаанбаатар хот

Дайнд оролцсон ахмад настнуудын талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1.3-т заасныг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосугай.

Нэг. Халхын голын байлдаанд ялсны 70 жилийн ойг угтан эх орныхоо тусгаар тогтнолын төлөө тэмцэж, 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайн, улсын баруун хил дээр 1940-1948 онд болсон зэвсэгт тулгаралтанд оролцсон ахмад настнуудын нийгмийн хамгаалал, нийгмийн халамжийг дээшлүүлэх талаар дараахь

1. Дайнд оролцсон ахмад настанд олгодог тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж, сар бүр олгох асуудлыг шийдвэрлэх;

2. Ахмад дайчдад орон сууц олгох, эсвэл түүнтэй адилтгах мөнгөн тэтгэмжийг нэг удаа олгох.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.ЭНХБАЯР**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
С.БАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 06 дугаар сарын 09-ны өдөр

Дугаар 171

Улаанбаатар хот

Элчин сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Монгол Улсаас Монакогийн Хант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Раднаабазарын Алтангэрэлийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

Дэлхийн сонгодог утга зохиолын 50 боть хэвлүүлэх тухай

Хүн төрөлхтөн өөрсдийн амьдрал, орчин тойрон, хүсэл мөрөөдлийн тухай анх хад чулуун дээр сийлэн зурж, улмаар бичиг үсэг бий болгож, уран яруу, утга гүнзгий үгээр илэрхийлсэн суут бүтээлүүдийг туурвиж, оюун билгийнхээ сан хөмрөгийг бүрдүүлэн баяжуулсан билээ. Олон зууны туршид бүтээгдсэн туульс, роман, тууж, эмгэнэлт болон инээдэмт зохиол, уран зөгнөл, яруу найраг зэргийн бүтээлүүдийн дээж сор нь он цагийн шалгуурыг давж, дэлхий дахинаа сонгодог утга зохиол хэмээн нэгэнт хүлээн зөвшөөрөгджээ.

Ард иргэдийнхээ оюуны санд ном эрдмийн өглөг өргөгч эрдэмтэд, зохиолч, орчуулагчид хүн төрөлхтөний бий болгосон сонгодог утга зохиолын их далайгаас сувд эрдэнэ мэтийг сорчлон дээжилж, 50 бүтээлийг хэвлүүлэх тухай санал гаргасныг дэмжиж, манай оронд уран бүтээлийн эвлэл холбоод үүсч хөгжсөний 80 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн 34

дүгээр зүйлийн 1-д заасныг баримтлан ЗАРЛИГ БУУЛГАХ НЬ:

1. Дэлхийн сонгодог утга зохиолын 50 ботийг 2008-2009 онд багтаан хэвлэж, нийтийн хүртээл болгосугай.

2. Дэлхийн сонгодог утга зохиолын 50 ботийг хэвлүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж, Ерөнхий боловсролын сургууль, аймаг, хотын номын сан, төрийн өмчийн их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт- үйлдвэрлэлийн төвүүдэд үнэгүй түгээх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД
С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 173

Улаанбаатар хот

"Монгол Улсын Үндэсний Номын Сан" байгуулах тухай

Номын сан бол хүн төрөлхтөний олон зууны тэртээгээс эх суурь нь тавигдаж, эрэн зуунуудыг өртөөлсөөр өнөө бидний үед хүрч ирсэн мэдээлэл, эх сурвалж, нөөц болон үйлчилгээний нэн баян сан хөмрөг бөгөөд цаг, мөч бүрийд ундарга нь сэлбэгдэх оюуны хөлгүй далай, зуун зуунд баялаг нь үл дундрах мэдлэгийн яндашгүй уурхай болой.

Монголчууд хүн төрөлхтөний буй болгосон номын энэ их сан хөмрөгт эрт цагаас хувь нэмрээ оруулж олон зууны тэртээ анхны "Чулуун ном" сийлж, 14 дүгээр зуунд анхны модон барын номыг хэвлэж ирсэн нь бидний бахархал мөн.

Монгол Улсад 1921 онд шинэ үеийн номын сангийн эх суурь тавигдаж, Монголын соёлын амьдралд онцгой үүрэг гүйцэтгэж ирснийг цохон тэмдэглэж, мэдээлэл, мэдлэгийн хэмээгдэх XXI зууны эхэнд дэлхийн шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн ололтод тулгуурласан сан хөмрөг, үйлчилгээ бүхий орчин цагийн номын сан барих зайлшгүй шаардлага бий болсныг үндэслэн, мөн

эрдэмтэд, урлаг соёлын зүтгэлтнүүдийн санал, санаачилгыг дэмжиж Монгол Улсын Үндсэн хуулийн 33.1.3, 34.1 дэх заалтыг тус тус баримтлан ЗАРЛИГ БУУЛГАХ НЬ:

1. "Монгол Улсын Үндэсний Номын Сан"-гийн шинэ иж бүрэн барилга, байгууламжийг бүтээн цогцлуулсугай.

2. "Монгол Улсын Үндэсний Номын Сан"-г барихад шаардлагатай хөрөнгийг гадаадын буцалтгүй тусламж болон Улсын төсөвт тусгах замаар шийдвэрлэхийг Засгийн газарт чиглэл болгосугай.

3. "Монгол Улсын Үндэсний Номын Сан" барихад бололцооны хэрээр хувь нэмрээ оруулахыг хувийн хэвшлийнхэн болон нийт ард иргэдэд уриалсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД
С.БАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 06 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

Цолны ялгах тэмдгийн тодорхойлолт, загвар батлах тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Дипломат албаны тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин цолны ялгах тэмдгийн

тодорхойлолтыг 1 дүгээр хавсралтаар, ялгах тэмдгийн загварыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 174 дүгээр зарлигийн 1 дүгээр хавсралт

Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин цолны ялгах тэмдгийн тодорхойлолт

Нэг. Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд цолны ялгах тэмдгийн тодорхойлолт:

1.1. "Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд" цолтонд алтан гэрэгэ олгоно.

Гэрэгэг зэсээр цутган хийж, алтаар шармалдах бөгөөд гэрэгэний голын цоорхойг тойруулж Их эзэн Чингис хааны нэрийн өмнөөс харь улсад зорчих элч, төлөөлөгчид олгодог байсан, ОХУ-ын Днепр мөрний хөвөөнөөс 1845 онд олдсон гэрэгэний жинхэнэ эх дээр байдаг уламжлалт хээ буюу эртний монголчуудын элэнц хуланц - эцэг эх хоёр гэдэг нар, сар болон ил далд хоёрыг хардаг хоёр билгүүн бүхий мөнх тэнгэрийг бэлгэдсэн монгол үндэсний хээг товойлгон дүрсэлнэ.

Гэрэгэний голын цоорхойн зүүн доод хэсэгт "Монгол Улсын Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд", баруун доод хэсэгт "Мөнх тэнгэрийн хүчин дор Их суу залийн ивээл дор" гэж худмын монгол үсгээр тус тус товойлгож бичнэ. Эдгээр бичвэр нь гэрэгэний адил алтадмал өнгөтэй байна.

Гэрэгэний ар талын голын цоорхойн дээд талд нь соёмбыг товойлгон дүрсэлж, доод талд нь "Энэхүү гэрэгэг 200_ оны..... дугаар сарынны өдрийн зарлигаар-ийн-д олгов, Монгол Улсын Ерөнхийлөгч-ийн-ийн-д олгов, Монгол Улсын Ерөнхийлөгч-ийн-ийн-д олгов" гэсэн бичвэрийг кирилл үсгээр сийлж бичнэ.

1.2. "Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд" цолтонд гэрэгэний дүрстэй цолны тэмдэг олгоно.

Энэхүү тэмдгийг зэсээр цутган хийж, алтаар шармалдана. Тэмдгийн голын цоорхойд улаан өнгийн бадмаараг чулуун шигтгээ байх бөгөөд голын цоорхойг тойрсон хээ нь цолны алтан гэрэгэний хээтэй ижил байна.

Тэмдгийн голын цоорхойн доод талд "Монгол Улсын Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд" гэж худмын монгол үсгээр аптлаг шар өнгөөр товойлгон бичнэ.

Тэмдгийн ар талд босоо байрлалтай сүлбээр зүүн хэлбэртэй зүүлт байна.

Хоёр. "Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин" цолны ялгах тэмдгийн тодорхойлолт:

2.1. "Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин" цолтонд мөнгөн гэрэгэ олгоно.

Гэрэгэг зэсээр цутган хийж, мөнгөөр бүрэх бөгөөд гэрэгэний голын цоорхойг тойруулж Их эзэн Чингис хааны нэрийн өмнөөс харь улсад зорчих элч, төлөөлөгчид олгодог байсан, ОХУ-ын Днепр мөрний хөвөөнөөс 1845 онд олдсон гэрэгэний жинхэнэ эх дээр байдаг уламжлалт хээ буюу эртний монголчуудын элэнц хуланц - эцэг эх хоёр гэдэг нар, сар болон ил далд хоёрыг хардаг хоёр билгүүн бүхий мөнх тэнгэрийг бэлгэдсэн монгол үндэсний хээг товойлгон дүрсэлнэ.

Гэрэгэний голын цоорхойн зүүн доод хэсэгт "Монгол Улсын Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин", баруун доод хэсэгт "Мөнх тэнгэрийн хүчин дор Их

суу залийн ивээл дор” гэж худмын монгол үсгээр тус тус товойлгож бичнэ. Эдгээр бичвэр нь гэрэгэний адил мөнгөлөг өнгөтэй байна.

Гэрэгэний ар талын голын цоорхойн дээд талд нь соёмбыг товойлгон дурсэлж, доод талд нь “Энэхүү гэрэгэг 200_ оны..... дугаар сарын-ны өдрийн зарлигаар-ийн-д олгов. Монгол Улсын Ерөнхийлөгч” гэсэн бичвэрийг кирилл үсгээр сийлж бичнэ.

2.2. “Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин” цолтонд гэрэгэний дүрстэй цолны тэмдэг олгоно.

Энэхүү тэмдгийг зэсээр цутган хийж, мөнгөөр бүрнэ. Тэмдгийн голын цоорхойд ногоон өнгийн маргад эрдэнийн чулуун шигтгээ байх бөгөөд голын цоорхойг тойрсон хэзэ нь цолны мөнгөн гэрэгэний хэзэтэй ижил байна.


Тэмдгийн голын цоорхойн доод талд “Монгол Улсын Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин” гэж худмын монгол үсгээр мөнгөлөг өнгөөр товойлгон бичнэ.

Тэмдгийн ар талд босоо байрлалтай сүлбээр зүүн хэлбэртэй зүүлт байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 174 дүгээр зарлигийн 2 дугаар хавсралт


**ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД,
ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН ЦОЛНЫ ЯЛГАХ
ТЭМДГИЙН ЗАГВАР**

**НЭГ. ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД ЦОЛНЫ
АЛТАН ГЭРЭГЭНИЙ ЗАГВАР**






ХОЁР. ОНЦ БЭГЭӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН ЦОЛНЫ МӨНГӨН ГЭРЭГЭНИЙ ЗАГВАР



ГУРАВ. ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД ЦОЛНЫ ТЭМДГИЙН ЗАГВАР



M = 1:1




M = 1:2

ДӨРӨВ. ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН ЦОЛНЫ ТЭМДГИЙН ЗАГВАР



M = 1:1



M = 1:2



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 06 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 175

Улаанбаатар хот

Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар тэргүүн түшмэлийн албан тушаалын зэрэг дэв зүйлийн 20.2 дахь хэсэгт заасныг үндэслэн олгосугай. ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Хавсралтад дурдсан нэр бүхий төрийн захиргааны албан хаагчдад төрийн захиргааны

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 175 дугаар зарлигийн хавсралт

№	Овог нэр	Албан тушаал	Албан тушаалын зэрэглэл	Олгох зэрэг дэв
1.	Михлайн Борбаатар	БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-14	Дэд зэрэг
2.	Гунгаагийн Баясгалан	ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-14	Гутгаар зэрэг
3.	Нацагийн Батсуурь	ХХААЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-14	Тэргүүн зэрэг
4.	Лувсанцэрэнгийн Пүрэвжав	УИХ-ын Тамгын газрын хэлтсийн дарга	АА-2	Тэргүүн зэрэг
5.	Чойжилын Нямсүрэн	УДШ-ийн Судалгааны төвийн захирал	АА-3	Дөтгөөр зэрэг
6.	Дуламын Сугар	Төрийн өмчийн хорооны дарга	ТЗ-13	Тэргүүн зэрэг
7.	Лувсандашийн Зориг	Үндэсний татварын ерөнхий газрын дарга	ТЗ-13	Тэргүүн зэрэг
8.	Дагвадоржийн Долгормаа	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга	ТЗ-13	Тэргүүн зэрэг

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 06 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 189

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Содовын Ононг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Европын Холбоонд суух

Онц бөгөөд Бүрэн эрх: Элчин сайдаар Авирмэдийн Баттөрийг томилсугай.

1. Монгол Улсаас Европын Холбоонд суугаа

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 06 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Монгол Улсаас Тайландын Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Яйчильын Батсуурийг эгүүлэн татсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 06 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 70 жилийн ойг тэмдэглэх тухай

Манай улсын бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг бататган бэхжүүлэх үйлсэд түүхэн ач холбогдолтой үйл явдал болсон Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 70 жилийн ой 2009 онд тохионо.

Халхын голын ялалт Алс Дорнодод гамшигт дайны аюулыг хазаарлан зогсоож, дэлхийн дайны галыг Евроазийн эх газарт хоёр талаас нь нэгэн зэрэг ноцоох гэсэн фашист эвслийн түрэмгий төлөвлөгөөг тасалдуулахад онцгой хувь нэмэр оруулсан билээ. Эдүгээ Халхын голын байлдаанд оролцсон талууд дэлхий дахины энх тайван, бие биенийхээ хөгжил, дэвшлийн төлөө жилээс жилд улам бүр ойртон нөхөрлөж, эв найрамдал, харилцаа, хамтын ажиллагааныхаа гэрэлт ирээдүйг хамтран дархалж байна.

Халхын голын 1939 оны байлдааны ялалтын ой бол манай ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэхийн төлөө, нийтийн дайсны эсрэг хамтын тэмцэлд оросын ард түмний үзүүлсэн тусламж, дэмжлэг, цэрэг дайчдын байгуулсан гавъяа, монгол-оросын ард түмэн, эзвэсэгт хүчний дайчдын нөхөрлөл, хамтын тэмцлийн үл балартах түүхийг хамтран дурсах тэмдэглэлт үйл явдал мөн.

Монгол эх орныхоо тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлын төлөө амь бие хайргүй

тулалдан, батлан хамгаалж, төр, ард түмнийхээ өмнө цэрэг эрс, ахмад үеийнхний маань байгуулсан гавъяа үеийн үед мөнхөд дурсагдаж байх учиртай.

Халхын голын түүхт ялалтын ойг тэмдэглэх талаар иргэд, иргэний нийгэм, төр, захиргааны байгууллагуудаас тавьж буй саналыг харгалзан, Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

1. Халхын голын 1939 оны байлдааны яруу алдарт ялалтын 70 жилийн ойг 2009 онд улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Энэхүү тэмдэглэлт ойг угтан, түүхэн ялалтын үнэ цэнэ, цэрэг эрсийнхээ байгуулсан гавьяаг судлах, сурталчлах, дайнд оролцогсод, ахмад дайчиддаа хайр халамж үзүүлэх, тэдний эх оронч сэтгэл, зүтгэлийг залуу залгамж үед өвлүүлэх, монгол-орос цэрэг эрсийн байгуулсан гавьяаг мөнхжүүлэх, хоёр ард түмний найрамдалт харилцаа, эзвэсэгт хүчний хамтын ажиллагааг шинэ нөхцөлд баяжуулан хөгжүүлэхэд түлхэц өгөхүйц цогц арга хэмжээг авч, хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.ЭНХБАЯР**
**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД
С.БАЯР**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 192

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин сайд Чулууны Батжаргалыг эгүүлэн гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, татсугай.

Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар 3. Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ Жаргалсайханы Энхсайханыг томилсугай.

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 193

Улаанбаатар хот

Элчин сайдыг томилох, чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин Тогтохбаярын Батбаатарыг тохоон томилсугай.

гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, 2. Өөр ажилд шилжсэнтэй нь холбогдуулан Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн Нямсүрэнгийн Алиасүрэнг Монгол Улсаас 3. Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар Камбожийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ эрхт Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

1. Монгол Улсаас Камбожийн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 197

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг Ерөнхий шүүгч, шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" тул Доржсүрэнгийн Төвшинтөрийг Нийслэлийн хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Шүүхийн тухай" Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн, ажил хэргийн Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.1, чадвар, мэргэшлийн түвшингийн хувьд шүүгчийн 58.1.3, 58.1.5 дахь хэсгийг тус тус баримтлан албан тушаалд тэнцэхгүй тухай Шүүхийн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ: Мэргэшлийн хорооны дүгнэлт гарсан тул

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн өөрөө хүсэлт гаргасан тул Ёндонгийн Ринзааныг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгчийн, биеийн эрүүл мэндийн байдлаар үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон

тул Дэмбэрэлийн Оюунчимэг, Дашийн Цагаандарь, Зэмбээгийн Энхтуяа нарыг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.3 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээсэн тул Лувсанпунцагийн Энхтунгалагийг Дундговь аймаг дахь сум дундын

шүүхийн шүүгчийн, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон тул Сайнцогтын Жаргалыг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус огцруулсугай.

 МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 92

Улаанбаатар хот

Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай

"Хүүхэд бүрт компьютер" хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай харилцан ойлголцлын санааж бичгийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хүүхэд бүрт компьютер" хөтөлбөрийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөрдлын төсвийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нэн тэргүүнд шаардагдах зардал 840,343,865.0 (найман зуун дөчин сая гурван зуун дөчин гурван мянга найман зуун жаран таван) төгрөгийг Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд нэмэлт оруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаанд даалгасугай.

3. "Хүүхэд бүрт компьютер" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж гадаад орон, олон улсын байгууллагатай хамтран санхүүгийн зохих дэмжлэг авч ажиллахыг Сангийн сайд Ч.Улаан, Гадаад хэргийн сайд С.Оюун, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ч.Сайханбилэг нарт тус тус даалгасугай.

 МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

САНГИЙН САЙД

Ч.УЛААН

 БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Н.БОЛОРМАА

Засгийн газрын 2008 оны 92 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"ХҮҮХЭД БҮРТ КОМПЬЮТЕР" ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд

Дэд дарга -Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга;

Гишүүд:-Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх (зөвшилцсөнөөр);

-Сангийн дэд сайд;

-Улсын гаалийн ерөнхий газрын дарга;

-Хүүхдийн төлөө үндэсний газрын дарга;

-Гадаад хэргийн яамны Америк, Ойрхи

дорнод, Африкийн газрын захирал;

-Сангийн яамны Зээл, тусламжийн нэгдсэн

бодлого, зохицуулалтын газрын дарга;

-Монголын үндэсний олон нийтийн радио,

телевизийн ерөнхий захирал (тохиролцсоноор);

-Сурах бичиг зохиогчдын холбооны

гүйцэтгэх захирал (тохиролцсоноор)

Нарийн бичгийн дарга -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Бага, дунд боловсролын газрын дарга.

Засгийн газрын 2008 оны 92 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

"ХҮҮХЭД БҮРТ КОМПЬЮТЕР" ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Дүн (төг)
1	Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны төсөв (цалин урамшуулал)	7 хүн	83,240.0
2	Гаалийн бүрдүүлэлт хийх, дотоодод тээвэрлэх, агуулах түрээслэх зардал	19000 компьютер	12,540.0
3	Орон нутагт компьютер хүргэх зардал	19000 компьютер	20,995.0
4	Сургалтын программ суулгах зардал (1 компьютерт 10000 төг)	20000 компьютер	20,000.0
5	Улсын төсвөөс худалдан авах компьютерийн зардал	3193 компьютер	703,568,865
6	Нэмэлт тоног төхөөрөмж	19000 компьютер	179,480.0
7	Сургалт	1800 хүн	100,000.0
8	Монгол агуулгыг хөгжүүлэх	303 агуулга	593,765,596
9	Сургалтын материалыг бэлтгэх (6 гарын авлага болон орчуулгын программ)	20000 компьютер	844,000.0
10	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын зардал	300 хүн	133,310.0
11	Жил бүрийн урсгал зардал	80 сургууль	124,080.0
	Дүн		2,814,979,461

Тайлбар: 1 ам.долларын ханшийг Монгол банкны 2008 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн ханшаар тооцсон болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 04 дүгээр
сарын 02-ны өдөр

Дугаар 125

Улаанбаатар
хот

Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 7.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуул, судалгааны ажил гүйцэтгэх "Голден Сий Петролиум" ХХК-ийн 510, "Петрожайна Дачи:

Тамсаг" ХХК-ийн 1810, "Доншен" ХХК-ийн 570, Ховд аймгийн Булган-Үенч-Ховд чиглэлийн 40 км хатуу хучилттай авто замын барилгын ажил гүйцэтгэх БНХАУ-ын "Чи тай зам гүүрийн компани"-ийн 191, "40 000 айлын орон сууц" хөтөлбөрийн хүрээнд барилгын ажил гүйцэтгэх "Мавангуй" Нөхөрлөлийн "00, "Хуанлу Хуантун" ХХК-ийн 350, "Их үйлсийн эрэлд" ХХК-ийн 800, "Богда холдинг" ХХК-ийн 300,



"Гандирс" ХХК-ийн 450, "Вилмар" ХХК-ийн 250, "Шилжэл шилтгэн" ХХК-ийн 100, "Стар Эстэйтс" ХХК-ийн 400, "Гангар" ХХК-ийн 350, "Зун Гуо Жизнь Жү Монгол" ХХК-ийн 450, "Номин констракшн" ХХК-ийн 160, "Манс-Арт" ХХК-ийн 150, "МКХ" ХХК-ийн 260, "Заг" ХХК-ийн 109 инженер техникийн болон мэргэжлийн ажилтанд 2008 онд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг зохих журмын дагуу олгохыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Д.Дэмбэрэлд даалгасугай.

2. "Голден Сий Петролиум" ХХК-ийн 510, "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн 1810, "Доншен" ХХК-ийн 570, "Чи тай зам гүүрийн компани"-ийн 191, "Их үйлсийн эрэлд" ХХК-ийн 800, "Богда холдинг" ХХК-ийн 300, "Гандирс" ХХК-ийн 450, "Манс-Арт"

ХХК-ийн 150, "Заг" ХХК-ийн 109 ажилтныг энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хугацаанд ажлын байрны төлбөрөөс чөлөөлсүгэй.

3. Энэхүү тогтоолын дагуу авч ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг 2008 онд багтаан буцаан гаргах ажлыг зохион байгуулж дүнг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд мэдээлэхийг холбогдох сийд нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД** **Д.ДЭМБЭРЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Дугаар 128 Улаанбаатар хот

Төсвийн зардлыг хэмнэх зарим арга хэмжээний тухай

Суурь бүтээгдэхүүний үнэ өссөнтэй холбогдуулан ажил, үйлчилгээний өртөг зардал нэмэгдэхээр байгааг харгалзан төсвийн байгууллагад зардал хэмнэх, оновчтой болгох замаар Улсын Их Хурлаас баталсан төсвөөс илүү зардал гаргахгүй байх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2. Улсын Их Хурлаас баталсан 2008 оны Монгол Улсын төсвөөс илүү зардал гаргахгүй байх, хэмнэлтийн зарчмыг баримтлан, бололцоотой зардлыг хэмнэх, санхүүжүүлэх хугацааг оновчтой тогтоох замаар хөрөнгийн эх үүсвэрийг чөлөөлөх зэрэг дараахь арга хэмжээг авч ажиллахыг нийт төсвийн захирагч нарт даалгасугай:

1. Үнэ өссөнтэй холбогдуулан хэмнэлт бий болгох замаар нэмэлт зардлыг санхүүжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрж болгосугай.

а) сургууль, эмнэлгээс бусад төсөвт байгууллагад эд хөрөнгө худалдан авах зардлыг 50 хувиар, урсгал засварын зардлыг 20 хувиар бууруулах;

а) 2008 оны Монгол Улсын төсвийн хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, баталсан төсвөөс илүү зардал гаргахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

б) төв, суурин газрын төсвийн байгууллагуудад халаалтын хэмнэлтийн горим сонгох, цахилгаан, усыг хэмнэх, ариг гамтай зарцуулах;

б) албан тушаалын болон албан ажлын автомашин хэрэглэх нормативыг 20 хүртэл хувиар хэмнэх, долоо хоногт нэг өдөр албан тушаалын болон албан ажлын унааг хэрэглэхгүй байх журмыг хэвшүүлэх;

в) гадаад албан томилолт, гадаад зочны зардлыг 30 хувиар бууруулах, Улсын Их Хурлын болон орон нутгийн хурлын сонгуулиуд болох гэж байгаатай холбогдуулан төрийн захиргааны байгууллагын дотоод албан томилолтыг багасгах;

в) хотын дотор шатахуун бага зарцуулдаг автомашин хэрэглэх, төрийн байгууллагын үйлчилгээний автомашин болон нийтийн тээврийн автобусыг шингэрүүлсэн шатдаг хийн түлшинд шилжүүлэх арга хэмжээ авах;

г) электрон шуудан, интернетийн холбоо ашиглах замаар шуудан холбоо, бичиг хэргийн зардлыг 10-аас доошгүй хувиар хэмнэх;

г) төсвийн байгууллагад эргэлтийн хөрөнгө бэлтгэх нөөц бүрдүүлэх нормативыг батлан мөрдүүлж бариа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, хөрөнгө түгжигдэх явдлаас сэргийлэх.

д) дүрэмт хувцсыг гамтай хэрэглэж, эдэлгээний хугацааг уртасгах замаар хэмнэлт бий болгох, тодорхой салбаруудад дүрэмт хувцас хэрэглэхээс татгалзах, хугацааг түр хойшлуулах;

е) ажлын байрны ачааллыг жигдрүүлэн нягтруулж зарим орон тоог чөлөөлөх, чөлөөтэй орон тоонд томилгоо хийхгүй байх, 2008 оныг дуустал цалин, орон тоог нэмэгдүүлсэн шийдвэр гаргахгүй байх.

3. Төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах замаар хэмнэлт гаргаж, нэмэгдэл хуримтлал бий болгох, авлагаа барагдуулж, өрөө дарах замаар санхүүгийн байдлыг сайжруулах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн хороо (Д.СУГАР), төрийн өмчийн болон төрийн өмчийн

оролцоотой аж ахуйн нэгжийн удирдлагад даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, төсвийн сар, улирлын хуваарьт шуурхай зохицуулалт хийж, төсвийн санхүүжилтийг оновчтой болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Ч.Улаанд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

САНГИЙН САЙД

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 04 дүгээр
сарын 09-ний өдөр

Дугаар 129

Улаанбаатар
хот

Монголын Үндэсний түүхийн музейг өөрчлөх тухай

Соёлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.2.4-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2. Монголын Үндэсний музейд шаардагдах зардлыг 2009 оноос жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаанд даалгасугай.

1. Үндэсний түүхийн музейг эрдэм шинжилгээ-судалгааны болон улс, аймаг, орон нутгийн музейг мэргэжил-арга зүйн удирдлага, мэдээллээр хангах үүрэг бүхий Монголын Үндэсний музей болгон өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

САНГИЙН САЙД

Ч.УЛААН

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Н.БОЛОРМАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 04 дүгээр
сарын 09-ний өдөр

Дугаар 136

Улаанбаатар
хот

Төсөл хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

сум, дүүрэгт агропарк байгуулах ажилд дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

1. Орон нутагт хэрэгжүүлэх "Агропарк" төслийг хавсралтын ёсоор баталсугай.

2. "Агропарк" төслийг улсын хэмжээнд хэрэгжүүлж, энэ ажлын хүрээнд явуулах сургалт, сурталчилгааг төрийн бус байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуягт,

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД**

Ц.ГАНХУЯГ

Засгийн газрын 2008 оны 136 дугаар
тогтоолын хавсралт

"АГРОПАРК" ТӨСӨЛ

Нэг. Үндэслэл

1. Ногоон хувьсгал хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээний дүнгээс үзэхэд өрхийн аж ахуй эрхлэгчдэд төмс, хүнсний

ногоог тариалах, хадгалах, хамгаалагдсан хөрсний тариаланг эрхлэх мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгөх үйл ажиллагаа орон нутагт дутагдаж байна. Төмс, хүнсний ногоо тариалж эхэлж байгаа өрх, иргэд тэдгээрийг тарих, арчлах, хураах, хадгалах

технологийг мэддэггүйгээс ургац алдаж, энэ ажлын эрч орон нутагт саарч байна. Мөн ажилгүй иргэдийг хөдөлмөр эрхлүүлэх, ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжүүлж байгаа "Үдийн цай" хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүдэд нарийн ногоо хэрэглүүлэх шаардлага ч гарч байна.

2. "Атрын гурав дахь аян" тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийн хүрээнд агропарк байгуулж шинээр тариалан эрхлэгчдэд төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах, арчлах, хураах, хадгалах технологийг зааж сургах, техникээр үйлчлэх, хураан авсан ургацыг нь хадгалах, иргэдийн орлогоо нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор агропарк төслийг боловсруулав.

Хоёр. Төслийн зорилго

3. "Агропарк" төслийн зорилго нь "Атрын гурав дахь аян" тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийн хүрээнд сум, дүүрэг бүрт агропарк байгуулан ашиглахад оршино.

Гурав. Төслийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4. Сум, дүүрэг бүрт нэг агропарк буюу төслийн хүрээнд 334 агропаркийг 2008 оны 4-7 дугаар сард багтаан байгуулна.

5. Агропарк нь 120 м²-аас доошгүй талбайтай дуслын усалгаа бүхий хүлэмж, 18-20 морины хүчтэй бага оврын тракторын иж бүрдэл, 30 тонноос доошгүй багтаамж бүхий төмс, хүнсний ногооны зоорьтой байна.

Дөрөв. Агропаркийн үйл ажиллагааны чиглэл

6. Сум, дүүргийн агропарк нь дараахь үйл ажиллагааг явуулна:

6.1. Шинээр тариалан эрхлэгчдэд төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах, арчлах, хураах, хадгалах технологийн сургалт явуулах;

6.2. Ил талбайд төмс, хүнсний ногоо болон хүлэмжийн аж ахуйд хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах иргэд, аж ахуйн нэгжид зөвлөгөө өгөх, сурталчилгаа хийх;

6.3. Тариалан эрхлэгчдийг газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглаж байгаа орчин үеийн дэвшилтэт техник, технологийн талаархи мэдээллээр хангах;

6.4. Өрхийн тариалан эрхлэгчдэд техникээр үйлчлэх, хураан авсан төмс, хүнсний ногоог нь хадгалах үйлчилгээ үзүүлэх;

6.5. Үйлдвэрлэл, сургалтын зориулалтаар төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалж, үр, суулгац үржүүлэх.

Тав. Төслийг хэрэгжүүлэх арга зам

7. Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон Хүнс, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын хөрөнгөөр агропаркийг байгуулна. Хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага агропаркад олгох бага оврын тракторыг нээлттэй сонгон шалгаруулалтаар авч сум, дүүрэгт олгоно. Зоорь, хүлэмж барих ажлыг тухайн нутаг дэвсгэрийн цаг агаарын онцлогт тохируулан төсөвт өртөгт багтаан сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар зохион байгуулна.

8. Агропарк төслийг зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх үүргийг хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

9. Агропаркийн үйл ажиллагаанд арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийг хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны олонтыг нэвтрүүлэх төв, түүний харьяа орон нутаг дахь салбар, төлөөлөгч хэрэгжүүлнэ.

10. Агропаркийн үйл ажиллагааг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар өдөр тутмын удирдлагаар, аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар мэргэжил, арга зүйн удирдлагаар тус тус хангаж, нэгдсэн хяналт тавин үйл ажиллагааны талаархи тайланг гаргаж жил бүрийн 12 дугаар сард хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

11. Агропаркийн үйл ажиллагааг өөрийн орлогоор нь санхүүжүүлнэ.

13. Агропаркийн өмчлөлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

12. Агропаркийн хөрөнгө нь аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын эзэмшилд байх бөгөөд иргэн, хоршоо, нөхөрлөлд гэрээгээр ашиглуулна.

Зургаа. Агропарк байгуулахад шаардагдах тоног төхөөрөмжийн зардал

14. Төслийн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлын хөрөнгө оруулалт:

д/д	Хөрөнгө оруулалтын төрөл	Нэгж үнэ (сая.төг)	Байгуулах сум, дүүргийн тоо	Нийт үнэ (сая.төг)
1	18-20 морины хүчтэй трактор (анжис, цант борной бүхий)	4.0	334	1336.0
2	120 м ² талбай бүхий нийлэг хальсан хүлэмж	2.5	334	835.0
3	30 тонны багтаамжтай зоорь	5.0	334	1670.0
Дүн		11.0	334	3841.0

Долоо. Төслийн шалгуур үзүүлэлт

15.2. Байгуулагдсан агропарк нь энэхүү төслийн 5-д заасан шаардлагыг хангасан байх;

15. Төслийг дараахь шалгуур үзүүлэлтээр хэмжинэ:

15.3. Агропарк бүр өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг болсон байх.

15.1. Сум, дүүрэг бүрт агропарк байгуулагдсан байх;

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр

Дугаар 140

Улаанбаатар хот

Тусгай зориулалтаар 2009 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай

Ан агнуурын тухай хуулийн 8.3, Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

3. Тогтоолын 1 дүгээр зүйлд заасан ан амьтныг тусгай зориулалтаар агнаж, барьсан зөвшөөрлийн хураамжийн орлогыг орон нутгийн төсвийн орлогод тооцож, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

1. 2009 онд тусгай зориулалтаар угалз 60, тэх 200, харсүүлтий 20, бор гөрөөс 50, цагаан зээр 100, саарал чоно 100, агнуурын шувуу 300 хүртэл, судалгаа шинжилгээний зориулалтаар хүрэн баавгай 2 толгой агнуулахаар, гадаад оронд амьдаар гаргах идлэг шонхор шувуу 240 хүртэл толгой байхаар тус тус тогтоосугай.

4. Олон улсын ангийн үзэсгэлэн худалдаанд Монгол Улсаас угалз, тэх зэрэг агнуурын зарим ховор ан амьтан агнах эрхийг дуудлага худалдаанд оруулах ажлыг зохион байгуулахыг Байгаль орчны сайд Г.Шийлэгдамбад зөвшөөрсүгэй.

2. Амьдаар барих нэг толгой идлэг шонхор шувууны жишиг үнийг 10000 ам.доллар, төлбөрийг 9000 ам.доллар, хураамжийг 800 ам.доллар байхаар тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр

Дугаар 144

Улаанбаатар хот

Хотөлбөр хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Төрийн нууцын жарсаалт батлах тухай хуулийн 1 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөрийн хүрээнд "Хаягжилтын нэгдсэн систем", "Иргэний ухаалаг үнэмлэх" төслүүдийг хэрэгжүүлэх хуулийн этгээдтэй байгуулах гэрээнд тусгах нөхцөл, шаардлагыг 1 дүгээр хавсралтын ёсоор зөвшөөрсүгэй.

2. "Хаягжилтын нэгдсэн систем", "Иргэний ухаалаг үнэмлэх" төслүүдийг хэрэгжүүлэх гэрээний нөхцөл, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг зохих журмын дагуу сонгож гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргил, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Энхболд, Барилга, хот

байгуулалтын сайд Ц.Цолмон, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ч.Сайханбилэг нарт даалгасугай.

3. Төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг төсөл тус бүрээр нь хянаж эргэн төлөгдөх нөхцөлөөр төсвөөс санхүүжүүлж холбогдох хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Улаанд даалгасугай.

4. Төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж явц, үр дүнг улирал бүр Засгийн газарт танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Энхболдод даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

Засгийн газрын 2008 оны 144 дүгээр тогтоолын хавсралт

"ХАЯГЖИЛТЫН НЭГДСЭН СИСТЕМ", "ИРГЭНИЙ УХААЛАГ ҮНЭМЛЭХ" ТӨСЛҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭНД ТУСГАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

1. Мэргэжлийн өндөр ур чадвар, дадлага, туршлага бүхий боловсон хүчин, техник, технологийн боломжтой байх;

2. Төсөл хэрэгжүүлэгч нь Монгол Улсын хуулийн этгээд байх бөгөөд хэрэв гадаадын хөрөнгө оруулалттай бол монголын талын оролцоо 66.0 хувиас доошгүй, удирдах албан тушаалтан нь Монгол Улсын иргэн байх;

3. Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг гаргах санхүүгийн чадвартай байх;

4. Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж, зарцуулсан хөрөнгийг тухайн төслийг хэрэгжүүлж дууссанаас хойш 12 сарын дотор эргэж төлөх нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн байх;

5. Тухайн төслийг "Монгол Улсын бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлж байгаа бусад төсөл, арга хэмжээтэй уялдуулах;

6. Төслийг хугацаанд нь чанарын өндөр түвшинд гүйцэтгэх чадвартай байх;

7. Холбогдох зураглал, код, иргэний ухаалаг үнэмлэхийн агуулга, багтаамж болон программ хангамж боловсруулах, дэд бүтцийг байгуулах, мэдээллийн санг бүрдүүлэх талаар төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан журам, аргачлал, стандартыг мөрдөх;

8. Хууль тогтоомжоор төрийн нууцын зэрэгт хамаарах бүх төрлийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллах.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 149

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

54 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны кодлосон жагсаалт"-д дор дурдсан хэсэг нэмсүгэй.

1. Монгол Улсын Засгийн газрын 2001 оны

Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн зүйл №	Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн мөр №	Барааны бичиглэл	Үндэслэл бүхий эрх зүйн акт	Улсын хилээр нэвтрүүлэх ялгаа
08.02	0802.90	Хуш модны үр-самар	Байгалийн ургамлын тухай хуулийн /1995/ 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	Гаргах

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

 МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

 МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 153

Улаанбаатар хот

"Дарханы төмөрлогийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.8 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дархан-Сэлэнгийн бүсэд орших төрийн эзэмшлийн төмрийн хүдрийн орд газруудыг ашиглах, "Дарханы төмөрлогийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн үйл ажиллагааг өргөтгөн техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд үүрэг болгосугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслийн нөхцөл, шаардлагыг хэрэгжүүлэх болон санхүүжилтийг үйл ажиллагааны ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй зохион байгуулах менежментийн гэрээг "Дарханы төмөрлогийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн удирдлагатай байгуулж ажиллахыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд даалгасугай.

 МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

 ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
САЙД

Х.НАРАНХҮҮ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 156

Улаанбаатар хот

Гамшиг судлалын хүрээлэн байгуулах тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 6.1.7, 12.1.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хүрээлэнг Гамшиг судлалын хүрээлэн болгон зохион байгуулсугай.

 МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

 МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД

М.ЭНХБОЛД

Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Онцгой байдлын албаны эрдэм шинжилгээний

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 15.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Гамшгаас хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 51 дүгээр тогтоолын хавсралтын "Нэг. Төсвөөс санхүүждэг" гэсэн хэсгийн 12 дугаар заалтын "гал унтраах 1 зэрэглэлийн 56 дугаар ангитай" гэсний

өмнө "гал унтраах III зэрэглэлийн 81 дүгээр анги" гэж, 22 дугаар заалтын "65 дугаар анги" гэсний дараа "Шуурхай бүлэг-105" гэж тус тус нэмж, мөн хэсгийн 24 дүгээр заалтыг хассугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 10.2, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3.4, 8.3.7-г тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалтыг хавсралтын ёсоор баталж, 2008 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдсүгэй.

2. Энэхүү техникийн зохицуулалтын 2.1.4 дэх заалт болон "Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим MNS SAC/RCP 1 стандартын шаардлагыг 2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсүгэй.

Техникийн зохицуулалтын тухай

3. Энэхүү техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг, Стандартчилал, хэмжил зүйн төвийн дарга Г.Гантөмөр, Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга Ц.Шийрэвдамба нарт тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД

Ц.ГАНХУЯГ

Засгийн газрын 2008 оны 159 дүгээр тогтоолын хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ MNTN 1:2008

1. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү техникийн зохицуулалтыг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд заавал дагаж мөрдөнө.

1.2. Энэхүү техникийн зохицуулалт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэн явуулахад тавих заавал биелүүлэх шаардлагыг тогтооно.

1.3. Энэхүү техникийн зохицуулалтыг согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгох, сунгах, үйлдвэрлэл явуулах, үйлдвэрлэлд хяналт тавих, тохирлын баталгаанд хамруулах, тохирлын үнэлгээ явуулах үйл ажиллагаанд баримтлах шалгуур болгон ашиглана.

2. Согтууруулах ундааны бүх төрлийн үйлдвэрлэлд тавих нийтлэг шаардлага

2.1. Согтууруулах ундааны үйлдвэрлэлд чанар, аюулгүй байдлын дотоод хяналт, удирдлагын тогтолцоог дараахь байдлаар бүрдүүлсэн байна:

2.1.1. согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын хяналтын тогтолцоог "Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим (олон улсын зөвлөмж)" MNS SAC/RCP 1 стандартын дагуу хэрэгжүүлсэн байх;

2.1.2. бүтээгдэхүүний чанарын асуудал эрхэлсэн алба, нэгж, ажилтантай байх;

2.1.3. үйлдвэрлэлийн дамжлагын болон түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний хяналтын лабораторитой байх;

2.1.4. хяналтын лаборатори нь "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага" MNS ISO/IEC 17025 стандартын шаардлагыг хангасан байх;

2.1.5. чанарын алба, нэгж, ажилтан нь бүтээгдэхүүний цуврал бүрийг дотоодын



хяналтын лабораторийн сорилтын үр дүнг үндэслэн чанарын гэрчилгээ үйлдэн баталгаажуулж, худалдаа үйлчилгээнд гаргаж байх;

2.1.6. Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэгч нь түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний иж бүрэн шинжилгээг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторид улиралд нэгээс доошгүй удаа, эсхүл шинээр үйлдвэрлэл эхэлсэн, үйлдвэрлэл удаан үргэлжлэхээр завсарласны дараа үргэлжилсэн үед хийлгэнэ. Шинэ түүхий эд хүлээн авсан тохиолдол бүрт иж бүрэн шинжилгээг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторид хийлгэж шаардлага хангасан нөхцөлд үйлдвэрлэлд хэрэглэнэ. Түүхий эд, бүтээгдэхүүний сорилт, шинжилгээ, баталгаажуулалттай холбогдон гарах зардлыг үйлдвэрлэгч бүрэн хариуцна.

2.2. Архи, спиртийн үйлдвэрлэлийн шугамын оролт, гаралтыг тоолууржуулсан зориулалтын төхөөрөмжөөр тоногдсон байна.

2.3. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн шугамын тоолуур нь Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн дагуу загварын туршилтад тэнцэж, улсын бүртгэлд бүртгэгдэн, баталгаажсан байна.

2.4. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн шугамын тоолуурт тавих хяналтыг Үндэсний татварын ерөнхий газрын дарга, Стандартчилал, хэмжил зүйн төвийн дарга нарын хамтарсан тушаалаар баталсан журмын дагуу явуулна.

2.5. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн түүхий эд, завсрын болон эцсийн бүтээгдэхүүнд үйлдвэрлэсэн он, сар, өдөр, ээлж, шугам, чанарын төлөв байдал (зэрэг, дугаар, тэнцсэн, тэнцээгүй гэх мэт)-ыг зааж тэмдэглэн энэ тухай нарийвчилсан бүртгэл хөтөлнө. Шаардлагатай гэж үзвэл холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр хуурамч бүтээгдэхүүнээс хамгаалах аргачлал, тэмдэглэгээ хэрэглэнэ.

2.6. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн асуудал хариуцсан дээд, дунд шатны удирдлага буюу үйлдвэр эрхэлсэн удирдлага, технологич, мастер, чанар, лаборатори болон хангамж, борлуулалтын асуудал хариуцсан ажилтан нь согтууруулах ундааны стандарт, техникийн зохицуулалт, чанарын хяналт, удирдлагын чиглэлээр сургалтад хамрагдсан албан ёсны гэрчилгээтэй байна.

2.7. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн технологич, лабораторийн эрхлэгч нь бакалавраас доошгүй боловсролын зэрэгтэй байх бөгөөд дор дурдсан мэргэжлийг эзэмшсэн байна:

2.7.1. технологич: исгэлтийн үйлдвэрлэлийн инженер-технологич, эсхүл хүнсний үйлдвэрлэлийн технологич мэргэжилтэй, исгэлтийн үйлдвэрлэлийн технологиор мэргэшсэн байх;

2.7.2. лабораторийн эрхлэгч: хүнсний хими-технологич, эсхүл химийн технологич, хүнсний үйлдвэрлэлийн технологич, лабораторийн шинжилгээний арга зүйд мэргэшсэн байх.

2.8. Үйлдвэрлийн мастер, лабораторийн лаборант нь бакалаврын зэрэгтэй, эсхүл тусгай дунд боловсролтой бөгөөд дор дурдсан мэргэжлийг эзэмшсэн байна.

2.8.1. мастер: хүнсний үйлдвэрлэлийн технологич байх;

2.8.2. лаборант: хүнсний үйлдвэрлэлийн технологич, эсхүл химийн технологич, лабораторийн арга зүйд мэргэшсэн байх.

2.9. Үйлдвэрлэлийн үндсэн ажилчид нь мэргэжлийн дамжаа, сургалтад хамрагдсан байна.

2.10. Согтууруулах ундааны үйлдвэрлэгч нь холбогдох стандарт, техникийн зохицуулалт шинээр гарсан болон шинэчлэгдсэн үед энэхүү техникийн зохицуулалтын 2.6, 2.7, 2.8-д заасан ажилтанг сургалтад хамруулах арга хэмжээг авна.

2.11. Эрх бүхий байгууллага буюу нийлүүлэгч, үйлдвэрлэгчээс олгосон чанарын баталгаа, гэрчилгээгүй түүхий эд, материал, бодис, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд ашиглахыг хориглоно.

3. Спиртийн үйлдвэрлэлд тавих шаардлага

3.1. Спиртийн үйлдвэрлэл нь "Согтууруулах ундаа, Исгэлтийн үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага. Хэсэг 1: Спиртийн үйлдвэрлэл" MNS 5273-1 стандартын шаардлагыг хангасан байна.

3.2. Спиртийн үйлдвэрлэл нь энэхүү техникийн зохицуулалтын 2 дахь хэсэг болон 3.1-д заасан шаардлагаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

3.2.1. үйлдвэрлэлийн шугамын оролт, гаралтыг хянах дараахь зориулалтын төхөөрөмжтэй байна:

3.2.1.1. улаан буудайн зарцуулалтад хяналт тавих санах ой бүхий автомат жин;

3.2.1.2. үйлдвэрлэсэн спиртийн эзлэхүүн (жин), чанга, нягт, температурыг хэмжих нарийн мэдрэмжтэй электрон (автомат) тоолуур.

3.2.2. спиртийн үйлдвэрлэлийн лаборатори нь дараахь үзүүлэлтийг тодорхойлно:

3.2.2.1. үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд, материалын холбогдох стандартад заасан чанар, аюулгүй байдлын үзүүлэлт;

3.2.2.2. технологийн болон ахуйн хэрэглээнд ашиглаж байгаа усанд "Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус" Э-ууль ахуйн шаардлага, түүнд тавих хяналт" MNS 900 стандартад заасан мэдрэхүйн үзүүлэлт болон pH, ерөнхий хатуулаг, нянгийн тоо, колититр, коллиндекс, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч.

3.2.2.3. үйлдвэрлэлийн үндсэн дамжлага, технологийн ажиллагааг хянах физик, хими, механикийн болон мэдрэхүйн үзүүлэлтүүд.

3.2.2.4. бэлэн бүтээгдэхүүн болох спиртэд "Этилийн спирт" MNS 178 стандартад заасан мэдрэхүйн болон физик, химийн бүх үзүүлэлт.

3.2.3. лабораторийн шинжилгээг хийхэд "Архи" шинжлэх арга MNS 2117, "Архи ба этилийн спиртэд агуулагдах хорт бичил хольцыг тодорхойлох хийн хроматографийн арга" MNS ГОСТ 4949, "Архи, этилийн спиртэд агуулагдах хорт бичил хольцыг тодорхойлох хийн хроматографийн арга" MNS GOST R 51698, "Исгэлтийн бүтээгдэхүүнд хортой хүнд металл, химийн зарим элементийг тодорхойлох-Бурэн ойтлын рентген флуоресценцийн арга" MNS 5036 стандартыг сонгон хэрэглэнэ.

3.2.4. спиртийн үйлдвэр нь эрх бүхий байгууллагаас тогтоосон нэг тонн түүхий эдгээс гарах спиртийн хэмжээ болон аппаратын гарц, хорогдлын нормативыг баримтлана.

4. Архины үйлдвэрлэлд тавих шаардлага

4.1. Архины үйлдвэрлэл нь "Согтууруулах ундаа, Исгэлтийн үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага. Хэсэг 2: Архины үйлдвэрлэл" MNS 5273-2 стандартад заасан шаардлагыг хангасан байна.

4.2. Архины үйлдвэрлэл нь энэхүү техникийн зохицуулалтын 2 дахь хэсэг болон 4.1-д заасан шаардлагаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

4.2.1. үйлдвэрлэлийн шугамын оролт, гаралт нь тоолууржуулсан зориулалтын төхөөрөмжтэй байна.

4.2.2. архины үйлдвэрлэлийн лаборатори нь дараахь үзүүлэлтийг тодорхойлно.

4.2.2.1. "Этилийн спирт" MNS 178 стандартад заасан мэдрэхүйн болон физик, химийн бүх үзүүлэлт;

4.2.2.2. энэхүү техникийн зохицуулалтын 3.2.2.2-т заасан үзүүлэлт;

4.2.2.3. бусад нэмэлт түүхий эд, материалын холбогдох стандартад заасан мэдрэхүйн болон физик, хими, механикийн үзүүлэлтүүд;

4.2.2.4. үйлдвэрлэлийн үндсэн дамжлага, технологийн ажиллагааг хянах мэдрэхүйн болон физик, хими, механикийн үзүүлэлтүүд;

4.2.2.5. бэлэн бүтээгдэхүүн болох архинд "Төрөл бүрийн архи, Техникийн ерөнхий шаардлага" MNS 179 стандартад заасан мэдрэхүйн болон физик, химийн бүх үзүүлэлт.

4.2.3. лабораторийн шинжилгээг энэхүү техникийн зохицуулалтын 3.2.3-т зааснаар хийнэ.

4.2.4. архины шошгололт нь "Савласан хүнсний бүтээгдэхүүний шошгололтод тавих ерөнхий шаардлага" MNS CAC 1 стандартын шаардлага хангасан байна. Шошгон дээрх мэдээлэл нь "Хүнсний бүтээгдэхүүний тухай хэрэглэгчдэд зориулсан мэдээлэл, Ерөнхий техникийн шаардлага" MNS 4579 стандартын шаардлагад нийцсэн байна.

5. Дарсны үйлдвэрлэлд тавих шаардлага

5.1. Дарсны үйлдвэрлэл нь "Согтууруулах ундаа, Исгэлтийн үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага. Хэсэг 3: Дарсны үйлдвэрлэл" MNS 5273-3 стандартын шаардлагыг хангасан байна.

5.2. Дарсны үйлдвэрлэл нь энэхүү техникийн зохицуулалтын 2 дахь хэсэг болон 5.1-д заасан шаардлагаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

5.2.1. дарсны үйлдвэрлэлийн лаборатори нь дараахь үзүүлэлтийг тодорхойлно.

5.2.1.1. үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд, материалын холбогдох стандартад заасан чанар, аюулгүй байдлын үзүүлэлт;

5.2.1.2. энэхүү техникийн зохицуулалтын 3.2.2.2-т заасан үзүүлэлт;

5.2.1.3. бусад нэмэлт түүхий эдийн холбогдох стандартад заасан мэдрэхүйн болон физик, хими, механикийн үзүүлэлтүүд;

5.2.1.4. үйлдвэрлэлийн үндсэн дамжлага, технологийн ажиллагааг хянах физик, хими, механикийн болон мэдрэхүйн үзүүлэлтүүд.

5.2.1.5. бэлэн бүтээгдэхүүн болох дарсанд "Төрөл бүрийн дарс, дарсны төрлийн бүтээгдэхүүн, Техникийн ерөнхий шаардлага" MNS 5074 стандартад заасан мэдрэхүйн болон физик, химийн бүх үзүүлэлт.

5.2.2. лабораторийн шинжилгээг энэхүү техникийн зохицуулалтын 3.2.3-т зааснаар хийнэ.

5.2.3. дарсны шошгололт, шошгон дээрх мэдээлэл нь энэхүү техникийн зохицуулалтын 4.2.4-т заасан шаардлагад нийцсэн байна.

6. Пивоны үйлдвэрлэлд тавих шаардлага

6.1. Пивоны үйлдвэрлэл нь "Согтууруулах ундаа, Исгэлтийн үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага. Хэсэг 4: Пивоны үйлдвэрлэл" MNS 5273-4 стандартын шаардлагыг хангасан байна.

6.2. Пивоны үйлдвэрлэл нь энэхүү техникийн зохицуулалтын 2 дахь хэсэг болон 6.1-д заасан шаардлагаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

6.2.1. пивоны үйлдвэрлэлийн лаборатори нь дараахь үзүүлэлтийг тодорхойлно.

6.2.1.1. үндсэн түүхий эд болох соёолжийн "Пивоны соёолж техникийн ерөнхий шаардлага" MNS 2108 стандартад заасан мэдрэхүйн болон физик, хими, микробиологийн бүх үзүүлэлт;

6.2.1.2. энэхүү техникийн зохицуулалтын 3.2.2.2-т заасан үзүүлэлт;

6.2.1.3. бусад нэмэлт түүхий эд, материалын холбогдох стандартад заасан мэдрэхүйн болон физик, хими, механикийн үзүүлэлтүүд.

6.2.1.4. үйлдвэрлэлийн үндсэн дамжлага, технологийн ажиллагааг хянах мэдрэхүйн болон физик, хими, механикийн үзүүлэлтүүд;

6.2.1.5. бэлэн бүтээгдэхүүн болох пивонд "Төрөл бүрийн пиво, Техникийн ерөнхий шаардлага" MNS 181 стандартад заасан мэдрэхүйн болон физик, химийн бүх үзүүлэлт.

6.2.2. пивоны шинжилгээ хийхэд "Хүнсний технологи. Согтууруулах ундаа. Соёолж шинжлэх арга" MNS 5136, "Хүнсний технологи. Согтууруулах ундаа. Соёолжийн сахар, сахар бишийн харьцааг тодорхойлох арга" MNS 5138, "Хүнсний технологи. Согтууруулах ундаа. Соёолжид Хартонгийн болон Колбахын тоо тодорхойлох арга Пикнометрийн арга" MNS 5137, "Пиво. Шинжилгээний дээж авах аргууд" MNS 2019, "Пивоны өнгөийг тодорхойлох арга" MNS 2016, "Пивоны хүчиллэгийг тодорхойлох арга" MNS 2017, "Пивоны нүүрсхүчлийн хий ба тогтворжилтыг тодорхойлох арга" MNS 2018, "Хөрөнгөтэй пивонд сүүний болон цууны хүчил үүсгэгч бактери, зэрлэг дрожжийг илрүүлэх, тоог тоолох микробиологийн арга" MNS 5055, "Хүнсний технологи. Согтууруулах ундаа. Пивоны хөөсийг тодорхойлох арга" MNS 5135, "Шар айрагны спирт ба анхны шүүсний нягт, хандлаг бодисыг тодорхойлох арга" MNS 2020 стандартыг сонгон хэрэглэнэ.

6.2.3. пивоны шошгололт, шошгон дээрх мэдээлэл нь энэхүү техникийн зохицуулалтын 4.2.4-т заасан шаардлагад нийцсэн байна.

7. Согтууруулах ундааны үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ явуулах, хяналт тавих

7.1. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн тохирлын үнэлгээг стандартчиллын төв байгууллага болон хүнсний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хамтран зохион байгуулна. Энэхүү үнэлгээг явуулахад шаардагдах зардлыг үнэлгээнд оролцогч байгууллагын тухайн жилийн төсөвт тусган улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

7.2. Согтууруулах ундааны үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ явуулах үйл ажиллагаа нь дараахь үе шатнаас бүрдэнэ:

7.2.1. согтууруулах ундааны үйлдвэрлэлд тохирлын гэрчилгээ авах тухай үйлдвэрлэгчийн хүсэлтийг хүлээн авч, холбогдох баримт бичгийг хянан үзэж үнэлгээ явуулах эсэх талаар шууд шийдвэр гарган хариу өгөх;

7.2.2. ажлын хэсэг согтууруулах ундааны үйлдвэрлэл явуулж байгаа газар дээр нь үнэлгээ хийж дүгнэлт гаргах;

7.2.3. ажлын хэсгийн дүгнэлтэд дүн шинжилгээ хийж шийдвэр гарган согтууруулах ундааны үйлдвэрлэлийн тохирлын гэрчилгээ олгох;

7.2.4. тохирлын гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд согтууруулах ундааны үйлдвэрлэлийн тохирлын байдалд магадлах шалгалт явуулах;

7.2.5. согтууруулах ундааны үйлдвэрлэлд давтан үнэлгээ буюу аттестатчилал явуулах.

7.3. Согтууруулах ундааны үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ явуулах ажлын хэсэгт хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, стандартчиллын төв болон орон нутгийн байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргын үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан болон бусад байгууллагын тохирлын үнэлгээний сургалтад хамрагдан мэргэшсэн, ашиг сонирхлын зөрчилгүй төлөөлөгчдийг оруулна.

7.4. Тохирлын үнэлгээ явуулахад олон улсын болон үндэсний дараахь баримт бичигт заасан шаардлага, зарчмыг үндэс болгоно:

7.4.1. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль;

7.4.2. "Тохирлын үнэлгээ. Тайлбар толь, ерөнхий зарчим" MNS ISO/IEC 17000 стандарт;

7.4.3. "Бүтээгдэхүүний баталгаажуулалтын байгууллагад тавих ерөнхий шаардлага" MNS ISO/IEC Guide 65 стандарт;

7.4.4. "Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүний баталгаажуулалтын үндсэн асуудал" MNS ISO/IEC Guide 67 стандарт;

7.4.5. "Чанарын тогтолцооны үнэлгээ, баталгаажуулалт бүртгэлийн байгууллагад тавих ерөнхий шаардлага" MNS ISO/IEC Guide 62 стандарт;

7.4.6. "Тохирлын үнэлгээ-Байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог бүтээгдэхүүний баталгаажуулалтад ашиглах заавар" MNS ISO/IEC Guide 53 стандарт;

7.4.7. "Чанарын болон байгаль орчны удирдлага (менежмент)-ын тогтолцоонд аудит явуулах заавар" MNS ISO 19011 стандарт.

7.5. Энэхүү техникийн зохицуулалтын шаардлагыг шалгуур болгон согтууруулах ундааны үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ явуулж шаардлага бүрэн хангасан үйлдвэрлэлд хүнсний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, стандартчиллын болон мэргэжлийн хяналтын төв байгууллагын хамтарсан "Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн тохирлын үнэлгээний зөвлөл"-өөр хэлэлцэн шийдвэрлэж "Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн тохирлын гэрчилгээ"-г 3 жил хүртэл хугацаагаар олгоно.

7.6. Техникийн зохицуулалтын мөрдөх явцад хяналт тавих магадлах шалгалтыг хүнсний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, стандартчиллын байгууллага, аймаг нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран орон нутгийн байгууллагуудын оролцоотойгоор жил бүр гаргасан хуваарийн дагуу явуулна.

7.7. Техникийн зохицуулалтын хэрэгжилтэд тавих байнгын хяналтыг төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

7.8. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн тохирлын гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл дээд шатны байгууллагын шийдвэрийн дагуу согтууруулах ундааны үйлдвэрлэлд давтан үнэлгээ буюу аттестатчилал явуулна. Давтан үнэлгээ явуулахад энэхүү техникийн зохицуулалтын 7.2.1-д заасныг хэрэглэхгүй.

7.9. Согтууруулах ундааны үйлдвэрлэл нь тохирлын хүчин төгөлдөр гэрчилгээтэй бол тухайн

үйлдвэрлэлд дахин үнэлгээ явуулахгүйгээр дараахь ажлыг хийхэд үг гэрчилгээг үндэслэл болгож ашиглана.

7.9.1. согтууруулах ундааны үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл олгох, сунгах буюу тендер шалгаруулах;

7.9.2. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 16.4, 16.12-т заасны дагуу бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ, үндэсний тохирлын тэмдэг олгох;

7.9.3. ажлын байрны дүгнэлт гаргах.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот

Тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.1 дэх хэсэг, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.2 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиудын дагуу олгох тусламж, хөнгөлөлтийн хэмжээг дор дурдсанаар тогтоож, 2008 оны 2 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй:

а) байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа олгох нөхцөлт мөнгөн тусламжийн хэмжээг 30000 төгрөгөөр;

б) гурав ба түүнээс дээш тооны бага насны (14 хүртэлх насны) хүүхэдтэй өрх толгойлсон эх (эцэг)-д жилд нэг удаа олгох нөхцөлт мөнгөн тусламжийн хэмжээг 60000 төгрөгөөр;

в) гурав хүртэлх насны ихэр хүүхдэд жилд нэг удаа хүүхэд бүрт олгох мөнгөн тусламжийн хэмжээг 60000 төгрөгөөр;

г) 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн болон гэнэтийн аюул, ослын улмаас гэр оронгүй болсон ерхөд гэр авахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор олгох нэг удаагийн мөнгөн тусламжийн хэмжээг 500000 төгрөгөөр;

д) орон сууцны хөлсний болон түлшний хөнгөлөлтөд жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн хэмжээг 140000 төгрөгөөр;

е) Монгол Улсын болон хөдөлмөрийн баатар, ардын цолтон, ахмад дайчин болон дайнд

оролцож яваад амь үрэгдсэн иргэний эхнэр (нөхөр)-т улирал бүр олгох мөнгөн тусламжийн хэмжээг 50000 төгрөгөөр;

ё) Монгол Улсын гавьяат болон төрийн соёрхолт, Улсын ударник, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн ахмад настанд жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн хэмжээг 100000 төгрөгөөр;

ж) насанд хүрсэн бүрэн хараагүй иргэний харилцаа, холбооны зардалд сар бүр үзүүлэх хөнгөлөлтийн хэмжээг 10000 төгрөгөөр;

з) нийслэл болон хот, суурин газарт нийтийн тээврийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд нь хүргэж өгч, авдаг асран хамгаалагч, харгалзан дэмжигч нэг хүнд унааны зардлын хөнгөлөлтийг жилд нэг удаа 90000 төгрөгөөр.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан «Тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай» Засгийн газрын 2006 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 133 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

САНГИЙН САЙД

Ч.УЛААН

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХОДОЛМӨРИЙН САЙД Д.ДЭМБЭРЭЛ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

☎ 265437
Хэвлэлийн хуудас 4